



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 9 сарын 27 өдөр

Дугаар 166

Улаанбаатар хот

Даатгалын хохирол үнэлэгчийн үйл  
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг  
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 4.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Капитал эстимэйт” ХХК-ийн даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “Капитал эстимэйт” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлтийг хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААДСҮРЭН